

**АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН 2022 ОНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 12

Дундговь аймаг. Эрүүл мэндийн газар

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв эх үүсвэр (сая, төгрөг)	Хэрэгжиж хугацаа	Хүрсэн үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь (Дээд шатны байгууллагын үнэлгээ, тайлбар)
НЭГ. ШУДРАГА ХАРИУЦЛАГАТАЙ, ИЛ ТОД АЛБЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР АВИЛГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАХ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ХААГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХДАА МЭДЛЭГ БОЛОВСРОЛД СУУРИЛАСАН МЕРИТ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР							
1.1	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1.1.1.Төрийн үйлчилгээнд хамаарах хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг мэдүүлэхээр заасан удирдах албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж хэвших, мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох.	-	2022	Ашиг сонирхлын зөрчилгүй этгээдийг албан тушаалд томилсон байна.	2022 оны байдлаар Уламжлалт анагаах ухааны төв нь УАУ-ны Нэгдсэн эмнэлэг болсноор дарга, Цагаандэлгэр, Баянжаргалан, Луус сумын эрүүл мэндийн төвийн түр орлон гүйцэтгэгч нар хянуулж ажилд томилогдсон байна. Ашиг сонирхолын зөрчилгүй гэж хариу ирүүлснээр 100 хувь албан тушаалд томилогдсон	100
		1.1.2. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) -ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгох.	-	2022	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байна. Дүгнэлтүүдийг байгууллагын цахим хуудсад байршуулсан байна.	Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн мэргэжилтэн, Уламжлалт анагаах ухааны төвийн нягтлан бодогч 1-ийг тус тус хянуулж ил тодоор байгууллагын вэб сайтад байршуулсан.	100

		1.1.3. Төрийн үйлчилгээний байгууллагын хүний нөөцийн жагсаалт, сул орон тооны мэдээллийг ил тод болгох	-	2022	Хүний нөөцийн жагсаалт ил тод нээлттэй болсон байна.	Хүний нөөцийн жагсаалт, сул орон тооны зарыг https://du.mohs.gov.mn/ ил тодоор байршуулсан 2022 оны 10 сарын байдлаар 83 орон тоо сул байна.	100
1.2	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	1.2.1. Албан тушаалын тодорхойлолтыг ёс зүй мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг ТАЗ-өөс баталсан журмын дагуу боловсруулан баталгаажуулж шинэчлэн батлах.	-	2022	Албан тушаалын тодорхойлолт батлагдсан байна	Өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-өөс өгсөн загварын дагуу хийж аймгийн ТАСЗ-ын тогтоолоор батлууллаа. Ёс зүй мэдлэг мэргэжил, туршлага, ур чадварыг тусгасан.	100
		1.2.2. Албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан, сонгон шалгаруулах журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж томилох, дэвшүүлэх.	-	2022	Байгууллага чадварлаг хүний нөөцтэй болсон байна.	Эрүүл мэндийн газарт шинээр 2 мэргэжилтэнг авч ажиллуулж байна. Нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж авсан.	100
1.3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг мөрдөх.	1.3.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд мэдээллийн ил тод байдлын бүрэн хангах холбогдох мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж “Цахим хуудас ажиллуулах, мэдээллийг цахим хуудсад байрлуулж, түгээх, ашиглах журам”-ыг байгууллагын хэмжээнд баталж, цахим хуудсад мэдээлэл байрлуулах албан тушаалтны нэрсийг хавсралтаар батлах.	-	2022	Мэдээллийн ил тод байдал хангагдаж ил тод байдалд өгөх хөндлөнгийн байгууллагын үнэлгээ сайжирсан байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн газрын даргын 2021 оны тушаалаар “Байгууллагын цахим хуудас ажиллуулах, мэдээллийг цахим хуудсад байрлуулж, түгээх ашиглах журам”-ыг батлаж цахим хуудсад мэдээлл байршуулах албан хаагчдын нэрсийг батлан гаргасан. https://du.mohs.gov.mn/ цэсэд байршуулсан. Хандалт 31042	100
1.4	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан	1.4.1. Авилгын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулж збх түвшний ажилтнуудыг хамруулах.	-	2022	Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад аймгийн эрүүл мэндийн салбарын нийт 35 удирдах албан тушаалтнуудыг хамрууллаа.	100

	сургах боломжийг бүрдүүлэх				сэргийлэх тухай мэдээ, мэдээллээр албан хаагчид хангагдсан байна.	Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтээс ирүүлж буй 14 төрлийн видео контентийг байгууллагын вэб сайт https://du.mohs.gov.mn/ пэйж хуудас сурталчилан танилцууллаа. Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн дагуу 4 сумын эрүүл мэндийн төвийн ажилтнуудад сургалт зохион байгуулж нийт 21 эмч мэргэжилтэн ажилтнууд хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны мэдээллийг нэг бүрчлэн хянан үзэж дутагдалтай ажиллаж буй эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт заавар зөвлөмжийг өгсөн. Нийт эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нарт Төсвийн тухай хууль, төсвийн хэмнэлтийн тухай хууль, авилгын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулиудаар аймгийн төвийн 21 удирдах ажилтан болон мэргэжилтнүүдэд сургалт хийсэн. Авилгын эсрэг гомдол мэдээлэл хүлээн авдаг 110 дугаар утасны дугаарыг бичсэн постерийг facebook хуудсаар түгээсэн.	
ХОЁР. ТӨСӨВ, САНХҮҮ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫГ САИЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ,, ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ҮР АШИГТАЙ, ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛАХ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР							
2.1	Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	2.1.1. Төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх.	-	2022	Эрүүл мэндийн яамтай хамтран ажилласан байна.	Төсвийн зарцуулалтад 2022 онд хийгдээгүй байна. 2020-2021 онд бараа материалын нийлүүлэлтэд хяналт хийсэн. Эрүүл мэндийн сайдын 358 дугаар тушаалаар ирүүлсэн дусал шингэнд дутагдал гарч, орлого аваагүй байсныг залруулсан.	100

2.2	Хандив, тусламж авахтай холбоотой хязгаарлалтыг мөрдөж, хариуцлагыг нэмэгдүүлэх.	2.2.1. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах.	-	2022	Хууль зөрчиж хандив, тусламж авах асуудал бүрэн зогссон байна.	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. Ийм зөрчил дутагдал илэрээгүй болно.	100
2.3	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиг сонирхлын зөрчлийг тухай бүр мэдэгдэл тайлбарлах.	2.3.1. Албан тушаалтнаас захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл, тайлбарыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гаргуулж хэвших.	-	2022	захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.	Тусгай зөвшөөрөл сунгах хурал хуралдахын өмнө тусгай зөвшөрлийн бүрэлдэхүүнд оролцож байгаа нийт гишүүд тус бүр 4 удаа гаргасан байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга 5 удаа гаргасан байна.	70
ГУРАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.							
3.1	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож үр ашигтай шудрага, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах.	3.1.1. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	-	2022	Тендер шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод болсон байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу tender.gov.mn сайтад тендер шалгаруулалтыг 100% цахимаар зохион байгуулж байна.	100
		3.1.2. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох	-	2022	Тендер шалгаруулалтын талаар гомдлын шийдвэрлэлт ил тод болсон байна.	Тендер шалгаруулалтын явцад гомдол санал ирээгүй. Тендерт шалгарсан комданий мэдэгдлийг tender.gov.mn сайтын үр дүн хэсэгт ил тод байрлуулан ажилласан.	100
		3.1.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайржуулж, ил тод болгох.	-	2022	Худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдаж олон нийтэд	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтын төсөл арга хэмжээ цэсэнд байршуулж эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах захиалгыг 22 багц болгон нээлттэй тендер зарлаж урилгыг сайтад ил тод байршуулсан	100

		3.1.4. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг нээлттэй ил тод мэдээлэх	-	2022	хардлага үүсгэхгүй болсон байна.	2022 онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн тайланг tender.gov.mn сайтад 2022 оны 12 сарын 1-ны дотор илгээж байршуулав.	100
		3.1.5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнууд мэгдэл, тайлбарыг тухай бүр гаргах	-	2022	Тендер шалгаруулалт хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулагдсан байна.	Эрүүл мэндийн газрын даргын А/28 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулагдан Эрүүл мэндийн газрын дарга болон нийт 4 гишүүнээс мэдэгдэл тайлбар дээр гарын үсэг зурж баталгаажуулсан.	100
		3.1.6. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг ойлгуулах, худалдан авах ажиллагааны мэдлэгтэй болгох зорилгоор АЗ гэрчилгээ олгох сругалтад ажилтнуудыг хамруулж, тухай бүр дендерийн хороог шинэчлэн байгуулж байх.	-	2022	Худалдан авах ажиллагаа тус бүрт үнэлгээний хорооош шинэчлэн байгуулах	Эрүүл мэндийн газрын даргын А/28 дугаар тушаал байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүд нь бүгд АЗ сертификаттай мөн цаашид хугацаа нь дуусах болон шинээр сурах хүсэлтэй мэргэжилтнүүдийн судалгааг Орон нутгийн өмчийн газар хүргүүлснээр 3 мэргэжилтэн сургасан.	100

ДӨРӨВ. АВИЛГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.1	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн байгууллагын ажилтнуудыг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах.	4.1.1. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	2022	Хагас жил, бүтэн жилээр тайланг гаргаж ЭМЯ-нд хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн яамнаас хүргүүлсэн авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласан Төлөвлөгөөний хэрэгжилт хувьтай	100
		4.1.2. Авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	-	2022	Байгууллагын ажилтнуудын авилгын эсрэг боловсрол дээшилсэн байна.	Авлигын эсрэг олон улсын өдөрийг “Дэлхий нийтээрээ авилгын эсрэг нэгдэе” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор эмнэлэг, эрүүл мэндийн төвийн удирдлагуудад цахим хурал хийлээ. Нийт 19 удирдлага оролцов. Авилга ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Аясал” ТББ-тай хамтран ажиллаж эрүүл мэндийн ажилтны авилга	70

					ашиг сонирхлын чигэлээр судалгаа авч хамтран ажиллаж байна.	
		4.1.3. Авилгын эсрэг сайн туршлагыг олон нийтэд түгээх.	-	2022	Авилгын эсрэг үйл ажиллагааг сайжруулах хүрээнд байгууллагын вэб сайтад авилгатай тэмцэх газраас ирүүлсэн контетуудыг тавь иргэдэд сурталчилсан. Мөн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд 2 удаа газар дээр очиж авилгын тухай хууль болон соён гэгээрүүлэх үйл ажиллагааны чиглэлээрх АХА тэмцээн зохион байгуулж нийт 200 гаруй иргэд оролцсон.	70
		4.1.4. Зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авилгыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах	-	2022	Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтээс ирүүлж буй 4 төрлийн видео контентийг байгууллагын вэб сайт https://du.mohs.gov.mn/ пэйж хуудас сурталчилан танилцууллаа.	40
<u>Хэрэгжилтийн дундаж хувь</u>						92,5

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН: УТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  П.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Б.АЛТАНТӨГС

